



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 112

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын "08," гэсний дараа "10 дугаар бүлгийн 1002.90.20, 1003.90.20, 1004.90.20, 1005.90.20 дахь үндэсний код, 11 дүгээр бүлгийн 11.01 дэх зүйл," гэж, "22.09 дэх зүйл," гэсний дараа "23 дугаар бүлгийн 23.02 дахь зүйл," гэж тус тус нэмсүгэй.

2."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-ний 10 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай дараах үндэсний код нэмсүгэй:

	1002.90.20	Тэжээлийн хөх тариа	5 хүртэл
	1003.90.20	Тэжээлийн арвай	
	1004.90.20	Тэжээлийн овьёос	
	1005.90.20	Тэжээлийн эрдэнэшишийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тус тус импортолсон бол	

3."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албантатварын хувь, хэмжээ"-ний 23 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 23.02 дахь зүйл нэмсүгэй:

	23.02	Үр тариа ба буурцагт ургамлыг шигших, тээрэмдэх, эсвэл бусад боловсруулалт хийх явцад гардаг хорголжилсон, эсвэл хорголжлоогүй хивэг, үртэс болон бусад үлдэгдлийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол	5 хүртэл
--	-------	--	-------------

4."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ"-ний 11 дүгээр бүлгийн "7 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл" гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний "15" гэсний дараа "хүртэл" гэж, мөн бүлгийн "4 дүгээр сарын 1-нээс 7 дугаар сарын 1 хүртэл" гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний "5" гэсний дараа "хүртэл" гэж тус тус нэмсүгэй.

